

АГУУЛГА



Бүртгэлтэй ажилгүйчүүд



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Цахилгаан холбоо

Аргачлалын тайлбар

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Мөнгө, банк

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

I_{ct}^L -т тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

P_{it} -'i' барааны тайлант үеийн үнэ,

P_{io} -'i' барааны суурь үеийн үнэ,

Q_{io} -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Нэгдсэн төсөв

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг. Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж хауй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2017 оны 06 дугаар сарын байдал)

Бүртгэлтэй ажилгүй иргэн


Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2019 оны 6 дугаар сарын эцэст 515 байгаа нь өмнөх оны мөн үеэс 459 (47.1%) хүнээр буурч, өмнөх сараас 316 (38%) хүнээр буурч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 287 (55.7%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 8 (1.5%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба тэдгээрийн бүгд эмэгтэйчүүд байна.

2019 оны 6 дугаар сард ажилгүй 280 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 147 иргэн ажилд зуулчлагдан орж, 596 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг өрхийн болон хувийн аж ахуй нь эрсдэлд орж орлогогүй боолсон иргэд 20.4 хувь нь, хамгийн бага хувийг хорих газраас суллагдсан иргэд буюу 0.7 хувь нь эзэлж байна.


Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 47.2 хувийг бүрэн дунд, 29.7 хувийг дипломын болон бакалаврын дээд, 11.5 хувийг техник мэргэжлийн, 4.5 хувийг суурь, 3.5 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.6 хувийг бага, 1.0 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 57.1 хувийг 15-34 насны залуучууд, 39.6 хувийг 35-54 насныхан, 3.3 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна

Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2019 оны эхний 6 сарын байдлаар




Хөдөлмөр, Халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй иргэд жил бүрийн 6 сарын байдлаар



Эрүүл мэнд


Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 6 сарын байдлаар 666 эх амаржиж, 674 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 46 (7.4%)-аар, амьд төрсөн хүүхэд 47 (7.5%)-аар тус тус нэмэгдсэн байна.



Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2019 оны эхний 6 сард 15 болж, өмнөх оны мөн үеэс 5 (50.0%)-аар, тав хүртэлх хүүхдийн эндэгдэл 3 болж, өмнөх оны мөн үеэс 1 (50.0%) -аар нэмэгдсэн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 222 болж, өмнөх оны мөн үеэс 96 (30.2%)-аар буурахад гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 73 (86.9%)-аар, хачигт рекетиоз өвчнөөр өвчлөгчид 14 (42.4%)-аар, салхинцэцэг өвчнөөр өвчлөгчид 17 (17.3%)-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин заг хүйтэн өвчнөөр өвчлөгчид 22 (2 дахин), сүрьеэ өвчнөөр өвчлөгчид 8 (1 дахин) өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2019 оны 6 сарын байдлаар




ТӨСВИЙН ОРЛОГО

Орон нутгийн төсөвт нийт 33.7 тэрбум төгрөг бүрдэж, төлөвлөгөө 101.6 хувиар, үүнээс улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 8.1 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 100.0 хувиар, тусгай зориулалтын шилжүүлэг 18.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 100.0 хувиар, орон нутгийн хөгжлийн сан 2.6 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөө 98.9 хувиар, орон нутгийн төсөвт

төвлөрүүлэх орлого 4.0 тэрбум төгрөгт хүрч 115. хувиар, татварын орлого 3.3 тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 108.2 хувиар, татварын бус орлого 623.3 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 2 дахин их биелүүлсэн байна. Аймгийн төсөвт байгууллагууд 2.4 сая төгрөгийн авлагатай, 257.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Төсвийн орлогын төрөл, мянган төгрөгөөр 2019 оны VI сард



ТӨСВИЙН ЗАРЛАГА

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн гүйцтгэл 30.2 тэрбум төгрөгт хүрч 73.8 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 90.6, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 87.2, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 90.4, нормативт зардал 42.1, эд хогшил, урсгал засварын зардал 97.2, томилолт, зочны зардлын 82.6, хөрөнгийн зардлын 35.7 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.


ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА ХУВИАР



Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл зугаадугаар сард өссөн дүнгээр 5.1 тэрбум төгрөг, үүнээс 79.1 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, 6.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 14.0 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 5.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

**Аж үйлдвэрийн салбарын
бүтээгдэхүүн үйлдвэрлэл
салбараар, 2019 оны 6 сарыг
байдлаар, хувиар**



- Уул уурхай, олборлох аж үйлдвэр
- Боловсруулах аж үйлдвэр
- Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж

**Аж үйлдвэрийн салбарын
бүтээгдэхүүн үйлдвэрлэл,
борлуулалт /сая төгрөг/**



Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2019 оны 6 дугаар сарын эцэст 112.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 5.4 тэрбум төгрөг буюу 5.0 хувиар өсчээ.

Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг

Үзүүлэлт	Хугацаа	
	2018-VI	2019-VI
Мөнгөний нийлүүлэлт M2	107438.9	112864.3
Сарын өөрчлөлт, хувиар	28.2	5.0
Нийт хадгаламж	87381.8	92077.5
Сарын өөрчлөлт, хувиар	29.3	5.4
Төгрөгийн хадгаламж	87175.0	91805.7
Сарын өөрчлөлт, хувиар	30.0	5.3
Валютын хадгаламж	206.9	271.7
Сарын өөрчлөлт, хувиар	-59.9	31.3

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 1.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 0.8 тэрбум төгрөг буюу 40.6 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын эцэст 123.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 14.7 тэрбум төгрөг буюу 13.5 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын эцэст 625.7 сая төгрөг болж, өмнөх оноос 33.1 сая төгрөг буюу 5.6 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.5 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээл 2019 оны 6 дугаар сарын эцэст нэг тэрбум 87.5 сая төгрөг болж өмнөх оноос 64.7 сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.9 хувийг эзэлж байна.

Үнэ


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2019 оны 6 дугаар сард суурь оноос 20.2, өмнөх оны мөн үеэс 8.7 хувь, өмнөх оны жилийн эцсээс 4.8 хувиар өсч, өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна. Ерөнхий индекс 2019 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 2.2 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2019-06 2015-12	2019-06 2018-06	2019-06 2018-12	2019-06 2018-05
Ерөнхий индекс	100	120.2	108.7	104.8	99.9
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	126.7	114.8	112.4	97.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	113.5	105.9	102.5	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	118.5	104.6	102.2	100.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	113.6	108.8	102.5	100.7
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	121.2	108.4	102.9	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	125.6	118.4	105.3	100.1
Тээвэр	12.2	120.6	108.5	100.3	100.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	97.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	109.2	104.1	101.4	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	116.4	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	153.1	115.8	112.2	110.1
Бусад бараа, үйлчилгээ	4.1	121.6	107.8	104.6	102.2


Ерөнхий индекс 2019 оны 6 дугаар сард жилийн эцсээс 4.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 12.4 хувь, хувцас, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн индекс 5.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны 6 дугаар сарын байдлаар төллөх насны 1570.8 мянган хээлтэгч малын 1120.4 мянга буюу 71.3 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 68.8 хувь, эм хонины 78.7 хувь, ингэний 43.8 хувь, үнээний 61.2 хувь, гүүний 60.4 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 96.9 хувь буюу 1086.4 мянган төл бойжиж байна. Том малын зүй бусын хорогдол 2019 оны 5 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд 37232 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 90.3 мянга буюу 3.4 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 1502, үхэр 1724, тэмээ 55, хонь 10930, ямаа 23021 байна. Нийт хорогдлын 29.4 хувийг хонь, 61.8 хувийг ямаа эзэлж байна.






Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2019 оны 6 дугаар сард аймгийн төв болох Есөнбулаг суманд ноолуур 82.0 мян.төг, хонины арьс 1.5 мян.төг, ямааны ноолуургүй арьс 500 төгрөг байна.

ЦАХИЛГААН ХОЛБОО


Суурин телефон цэгийн тоо 521, холбоо ашиглалтын орлого 159.1 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 111.4 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний нэг цэгээр 16 суудалтай ажиллаж, интернетээр дунджаар 0.4 мянган хүнд үйлчилжээ.

Харилцаа холбооны үйлчилгээний орлого сая төгрөгөөр



■ 2018 оны VI сард ■ 2019 оны VI сард

Суурин утасны цэгийн тоо




■ 2018 оны VI сард ■ 2019 оны VI* сард

Онцгой байдлын газар: Хагас жилийн байдлаар 36 удаагийн гал түймэр гарчээ. Тус газраас 5230 айл өрх, 129 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, 183.0 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварсан байна. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалсан гал түймрийн улмаас 117.0 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Нийт 36 удаагийн гал түймэр гарсны 10 галыг газар дээр нь унтрааж, өөрөө унтарсан гал түймэр 6, иргэд 20 гал түймрийг өөрсдөө унтраасан байна.

Гэмт хэрэг: Байгууллага, иргэдийн 323.4 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 146 гэмт хэрэг гарч, 112 (76.7%) хөнгөн, 34 (23.3%) хүнд гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Эдгээр хэргүүдээс хүний амьд явах эрхийн эсрэг гэмт, хулгай, залилах, хүрээлэн байгаа орчны эсрэг хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, хөрөнгө завших хэргүүд 82.8 хувийг, бусад хэрэг 17.2 хувийг эзлэж байна. Нийт хэргийн 58.9 хувь нь Есөнбулаг сум буюу аймгийн төвд гарсан хэрэг эзэлж байна. Хүнд гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 12 (54.5%), хөнгөн гэмт хэргийн тоо 51 (54.5%) малын хулгай 10 (2.6 дахин), хүрээлэн байгаа орчны эсрэг хэрэг 4 (3 дахин), өмчлөх эрхийн гэмт хэрэг 22 (42.3%)-иар тус тус өссөн байна.


Гэмт хэрэг



■ Гэмт хэрэг ■ Учирсан хохирол /сая төгрөгөөр/


Говь-Алтай аймгийн 2019 оны 8-р сарын цаг агаарын урьдчилсан төлөв:

Агаарын температурын сарын дундаж нь баруун хэсгээр 17-22 градус, өмнөд хэсгээр 20-25 градус, хойд хэсгээр 3-18 градус буюу ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 0.5-1.5 градусаар дулаан байна (3 дугаар зураг).



Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр бага зэрэг сэрүүсч Алтай, уулархаг нутгаар шөнөдөө 1-6 градус, өдөртөө 14-19 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 15-20 градус, өдөртөө 25-30 градус, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус өдөртөө 20-25 градус дулаан байна.

Гуравдугаар арав хоногийн сүүлчээр Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүйтэн, хөрсөн дээр 0-5 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 9-14 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 9-14 градус, өдөртөө 20-25 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 15-20 градус дулаан байна. Бусад хугацаанд Алтайн уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 18-23 градус, Алтайн өвөр говиор шөнөдөө 19-24 градус өдөртөө 29-34 градус, бусад нутгаар шөнөдөө 11-16 градус өдөртөө 23-28 градус дулаан байна. (4 дүгээр зураг).



Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхээр нутгийн зарим газраар түр зуурын бороо, нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зүүн хэсгээр, сүүлчээр нь ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн зарим газраар, сүүлчээр нь нутгийн хойд хэсгээр бороо, сарын эцсээр уулархаг нутгаар хур тунадас орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар түр зуур 18-20м/с хүрч ширүүсч болзошгүй.

Эх үүсвэр: Говь-Алтай УЦУОШТ-ийн УМХ Утас: 70483093

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

мян.мөз thous.tug

ОРЛОГЫН ТӨРӨЛ	INCOME TYPE	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
НИЙТ ОРЛОГО		33167,349.4	33681,821.7	101.6
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН				
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ		8113,567.5	8113,567.5	100.0
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ		18961,645.9	18961,645.9	100.0
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН		2625,144.0	2595,167.9	98.9
ШИЛЖЭЭГҮЙ ҮЛДЭГДЭЛ		-	-	-
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		3466,992.0	4011,440.4	115.7
1. ТАТВАРЫН ОРЛОГО		3189,012.5	3306,009.4	103.7
1.1 Орлогын албан татвар		2355,003.3	2548,307.8	108.2
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар		2905,003.3	2998,270.9	103.2
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого		2167,792.7	2328,232.1	107.4
Үйл ажиллагааны орлого		180,865.8	65,497.9	36.2
Хөрөнгийн орлого		475,949.0	529,481.6	111.2
Хөрөнгө борлуулсны орлого		34,980.0	34,207.3	97.8
Шууд бус орлого		45,415.8	40,852.0	90.0
1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(550,000.0)	(449,963.1)	81.8
1.2 Хөрөнгийн албан татвар		383,158.6	357,590.3	93.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		151,530.6	83,989.4	55.4
Галт зэвсгийн албан татвар		25,168.0	14,906.8	59.2
татвар		206,460.0	258,694.1	125.3
Малд ногдуулах албан татвар		-	-	0.0
1.3 Бусад татвар, төлбөр, хураамж		450,850.6	400,111.3	88.7
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж		157,284.8	148,494.9	94.4
Улсын тэмдэгтийн хураамж		75,439.8	88,011.5	116.7
Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт		(5,000.0)	(1,434.0)	28.7
Түгээмэл тархцтай ашигт малтмал ашигласны төлбөр		5,050.0	2,098.9	41.6
Хог хаягдлын хураамжийн төлбөр		81,795.0	59,818.5	73.1
1.3.2 Газрын төлбөр		225,582.8	135,309.7	60.0
Үүнээс: Газрын төлбөр		225,582.8	135,309.7	60.0
Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт		-	-	0.0
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр		67,667.0	66,509.4	98.3
Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр		-	163.2	0.0
Ан, амьтны нөөц ашигласны төлбөр		7,217.0	28,331.5	392.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		60,450.0	38,014.7	62.9
Байгалийн ургамал ашигласны төлбөр		-	-	0.0
1.3.4 Бусад татвар		316.0	49,797.3	0.0
2. Татварын бус орлого		262,979.5	623,341.0	237.0
Хүү, торгуулийн орлого		227,712.0	592,510.7	260.2
Төсвийн байгууллагын өөрийн орлого		-	-	0.0
Түрээсийн орлого		14,867.5	13,888.8	93.4
Бусад орлого		20,400.0	16,941.5	83.0
3. Хөрөнгийн орлого		15,000.0	82,090.0	0.0
Өмч хувьчлалын орлого		15,000.0	82,090.0	0.0
УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО		531,810.0	952,730.7	179.1
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		51,900.0	98,041.1	188.9
НӨАТатвар		442,400.0	811,412.4	183.4
Онцгой албан татвар		18,000.0	15,200.0	84.4
Агаарын бохирдлын төлбөр		15,310.0	12,428.7	81.2
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		4200.0	15648.5	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE soum

мян.төг thous.tug

№	Сум	Soum	Нийт орлого	Gross income	
			Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	429,945.0	429,169.8	97.6
2	Алтай	Altai	18,108.0	29,146.3	104.6
3	Баян-Уул	Bayn-Uul	31,919.0	25,658.9	123.1
4	Бигэр	Biger	16,984.0	24,209.1	156.5
5	Бугат	Bugat	19,816.0	29,452.8	142.3
6	Дарив	Dariv	18,650.0	25,566.7	113.6
7	Дэлгэр	Delger	20,050.0	21,027.3	130.6
8	Жаргалан	Jargalan	16,189.6	22,603.0	143.7
9	Тайшир	Taishir	8,887.0	10,280.5	116.3
10	Тонхил	Tonhil	40,236.0	82,078.4	150.0
11	Төгрөг	Tugrug	28,079.4	29,227.5	114.9
12	Халиун	Khaliun	8,534.0	14,846.7	133.2
13	Хөхморьт	Khukhmorit	15,510.0	18,143.2	111.3
14	Цогт	Tsogt	21,658.0	23,395.2	106.5
15	Цээл	Tseel	30,256.0	40,236.8	117.5
16	Чандмань	Chandmani	22,764.0	21,956.4	123.6
17	Шарга	Sharga	13,330.0	19,205.9	129.6
18	Эрдэнэ	Erdene	16,029.8	21,918.2	182.0
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	7,190.0	8,899.8	143.7
20	Гуулин тосгон	Guulin	7,847.1	10,383.5	182.0
21	Татварын хэлтэс	Straight communicant	2675,009.1	3104,034.4	111.6
	Дүн		3466,992.0	4011,440.4	112.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

/мян.мөг, thous.tug/

Төрөл type	Төлөвлөгөө Project	* Гүйцэтгэл Performance	Хувь Rate
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40951,764.3	30224,060.4	73.8
НИЙТ ЗАРЛАГА	39391,481.7	30242,198.8	76.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34577,850.0	28524,402.0	82.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30003,219.3	26077,686.4	86.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19059,833.4	17276,835.8	90.6
Үндсэн цалин	15602,894.6	14381,906.7	92.2
Нэмэгдэл	716,336.9	566,368.0	79.1
Унаа хоолны хөнгөлөлт	95,553.2	85,613.9	89.6
Урамшуулал	1527,295.2	1172,186.9	76.7
Гэрээт ажлын хөлс	1117,753.5	1070,760.3	95.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2396,691.0	2089,941.4	87.2
Тэтгэврийн даатгал	1619,173.5	1439,249.0	88.9
Тэтгэмжийн даатгал	189,550.2	165,542.4	87.3
ҮОМШӨ-ний даатгал	151,642.2	131,522.8	86.7
Ажилгүйдлийн даатгал	57,227.5	39,463.1	69.0
Эрүүл мэндийн даатгал	379,097.6	314,164.2	82.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3110,894.7	2811,338.4	90.4
Гэрэл, цахилгаан	227,849.3	201,358.5	88.4
Түлш, халаалт	2793,579.7	2541,936.3	91.0
Цэвэр, бохир ус	89,465.7	68,043.7	0.0
Байрны түрээс	745,891.1	622,085.3	83.4
Хангамж, бараа материалын зардал	745,891.1	622,085.3	83.4
Бичиг хэрэг	136,845.9	78,649.0	57.5
Тээвэр, шатахуун	879,036.2	465,467.5	53.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	133,283.9	69,539.9	52.2
Ном, хэвлэл	40,020.4	34,630.6	86.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,327.0	25,700.8	63.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	126,473.2	71,903.3	56.9
Нормативт зардал	2357,778.1	991,663.7	42.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	323,203.9	188,177.0	58.2
Хоол, хүнс	1948,374.6	744,924.0	38.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	86,199.6	58,562.7	67.9
Эд хогшил, урсгал засварын зардал	1016,190.7	988,085.4	97.2
Багаж, техник, хэрэгсэл	266,349.5	252,087.6	94.6
Тавилга	46,842.4	43,872.4	93.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,440.0	5,275.0	62.5
Урсгал засвар	694,558.8	686,850.4	98.9
Томилолт, зочны зардал	78,649.0	64,994.1	82.6
Гадаад албан томилолт	254,278.8	190,771.2	75.0
Дотоод албан томилолт	1740,813.6	1102,865.4	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1524,515.4	922,129.5	60.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил			
үйлчилгээний төлбөр хураамж	61,165.5	52,446.0	85.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,675.0	16,761.3	77.3
Даатгалын үйлчилгээ	6,818.0	3,406.6	50.0
Тээврийн хэрэгслийн татвар	3,017.6	955.9	31.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	107,106.7	98,613.0	92.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,373.9	851.3	25.2
Газрын төлбөр	5,441.5	2,888.7	53.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	0.0	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

	Үргэлжлэл мян.төг, tous.tog		
	Төлөвлөгөө <i>Project</i>	* Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	4,813.1	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	715,067.6	572,942.8	80.1
Бараа үйлчилгээний бусад зардал	597,494.0	499,010.0	83.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,573.6	73,932.8	62.9
ТАТААС	11,666.9	8,333.5	71.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	11,666.9	8,333.5	71.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4562,963.8	2438,382.2	53.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4092,155.6	2097,004.0	51.2
Засгийн газрын дотоод шилжүүлэг	4092,155.6	2097,004.0	51.2
Бусад урсгал шилжүүлэг	470,808.2	341,378.2	72.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	88,700.0	40,800.0	46.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	218,135.4	212,796.0	97.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,568.6	5,817.8	18.4
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ая	0.0	0.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	132,404.2	81,964.4	61.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4813,631.7	1717,796.8	35.7
Бусад хөрөнгө	4813,631.7	1717,796.8	35.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1560,282.6	-18,138.5	-1.2
Эргэж төлөгдөх зээл	1560,282.6	-18,138.5	-1.2
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2599,131.2	5460,203.3	-210.1
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2599,131.2	-5460,203.3	-210.1
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2599,131.2	-5460,203.3	-210.1
Өмч хувьчлал	0.0	7632,024.0	0.0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0	0.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE *soum*

мян.мөг, thous.tug

